

“ДЦС-4” ТӨХК

Огноо: 2019 оны 06 дүгээр сар 28

**ТӨРӨЛ БҮРИЙН ХИАМ НИЙЛҮҮЛЭХ
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Харьцуулалт/гэрээний
дугаар: **ХХА-2019/224-1**

НЭГ. **ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА**

ДЦС-IV ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Төрөл бүрийн хиам нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг** урьж байна. Тендер нь түүнийг нээсэн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээс үнэ төлбөргүй авч болно.

Үнийн саналыг **2019 оны 07-р сарын 05-ны өдрийн 10.000** цагаас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээр илгээх бөгөөд 1 хувийг цаасаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 оны 07-р сарын 05-ны өдрийн 10.30-т** цахим системээр нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

“ДЦС-4” ТӨХК ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС
Улаанбаатар хот Баянгол дүүрэг 20-р хороо Эрчим хүчний гудамж
Захиргааны байр 3-р давхар 311,312 тоот өрөө
Утас:70181309, 7017-1357

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|---|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) ТОӨЗ-д заасан шаардлагууд |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарыт заасан бараа нь нэг багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь запруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна. |

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫХОЛБОГДОХ ЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p>Сүүлийн хоёр жилийн /2017,2018он/ тус бүрийн борлуулалтын орлого тендерт санал болгосон үнийн дүнгээс багагүй байх</p> <p>Сүүлийн 2 жилийн туршлагын мэдээлэл /гэрээний хуулбарын хамт/</p> <p>Бусад нэмэлт шаардлага:</p> <p>Өөрөө үйлдвэрлэгч компани байх /Нотлох баримт ирүүлэх/</p> <p>Албан ёсны лабораторын дүгнэлт ирүүлэх</p> <p>Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар,</p> <p>НӨАТ төлөгчийн гэрчилгээний хуулбар</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: 2019 оны 07-р сарын 05-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минутаас өмнө</p> <p>Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn</p> <p><u>Сайтад илгээх бөгөөд нэг хувийг цаасаар ирүүлнэ</u></p>
ТОӨЗ 2.1	<p>Тендер нээх хаяг, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: “ДЦС-4” ТӨХК Худалдан авах ажиллагааны хэлтэс Улаанбаатар хот Баянгол дүүрэг 20-р хороо Эрчим хүчний гудамж</p> <p>Давхар болон өрөөний дугаар: Захиргааны байр 3-р даевхар 310 тоот өрөө</p> <p>Огноо: 2019 оны 07-р сарын 05-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 30 минут</p>
ТОӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: ХХА-2019/224-1 Төрөл бүрийн хиам</p> <p>Нийлүүлэх нэр бүхий 1 багцаас бүрдэнэ</p>

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Барааны тодорхойл олт	Тоо хэмжээ	Хэмжи х нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг (Ажлын талбай)	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа (Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7	8
Гахайн утсан мах	Техникийн тодорхойлолтод зааснаар	500	кг	“ДЦС-4” ТӨХХК Хүнсний агуулах	Гэрээ байгуулалтадсан хошиг захиалалын дагуу 1 жилийн дотор	Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Чанамал хиам		600	кг				[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Чанамал гахайн махан хиам		300	кг				[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Бүтэн утлагат хиам		100	кг				[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Хагас утлагат хиам		900	кг				[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Царцаамаг хиам		100	кг				[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Цагаан Зайдас		100	кг				[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Гахайн өөхтэй Зайдас		350	кг				[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Махан Зайдас		550	кг				[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]

Жич: Төрөл тус бүрээс дээж ирүүлэх

ТӨРӨЛ БҮРИЙН ХИАМАНД ТАВИГДАХ ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Хиам үйлдвэрлэгч байгууллага нь ISO 22000 стандартыг хэрэгжүүлсэн байна. Түүхий, эд бүтээгдэхүүнээ дотооддоо хянадаг өөрийн гэсэн лабораторитой.

Үйлдвэрлэлийн шат дамжлага бүртээ НАССР зарчим, мөрдлөгүүдийг төлөвлөж хэрэгжүүлдэг. Бүтээгдэхүүн бүр нь үндэсний тохирлын гэрчилгээ тэмдэгтэй.

Махаа өөрсдөө бэлтгэдэг, мах нядалгааны газартай. Түүхий эд материал хадгалах агуулах нь мэргэжлийн хяналтын газрын дүгнэлттэй. Хиам үйлдвэрлэлд хэрэглэх үндсэн ба туслах түүхий эд нь чанар, аюулгүй байдлын үзүүлэлтээрээ тухайн түүхий эдийн стандартын шаардлагыг хангасан.

“MNS 5023:2001, Max махан бүтээгдэхүүн. Эрүүл ахуй, аюулгүй байдлын үндсэн шаардлага” стандартын шаардлага хангасан үйлдвэр цехэд зохих журмын дагуу баталгаажуулсан жор, технологийн зааврын дагуу үйлдвэрлэдэг.

“CAC 192-1995(7-2006) Хүнсний нэмэлтийн ерөнхий стандарт”-ын болон Хүнсний нэмэлтийн ОУТС-ийн жагсаалтанд орсон хүнсний нэмэлтүүдийг хэрэглэж үйлдвэрлэсэн байна.

Туршлагын хувьд: Манайхтай ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг хоолны газар /ойролцоо хүчин чадалтай / -т 3-аас дээш байгууллагад хиам, хиаман бүтээгдэхүүн нийлүүлсэн туршлагатай. /Гэрээний хамт/

Төрөл бүрийн хиамны мэдрэхүйн эрхтний үзүүлэлтүүд

Бүтээгдэхүүний төрөл	Үзүүлэлтүүд			
	Гадаад байдал	Огтполын байдал	Өнгө	Амт, үнэр
Чанамал хиам	Бүрхүүл хальс нь гэмтээгүй, толбогүй, гадаргуу нь цэвэр, хуурай байна.	Таташ нь нягт, жигд шахалттай, бутарч унахааргүй, уян зөөлөн, хөндий зайд үүсээгүй, өөх нь жигд тархсан, хайлж урсаагүй байна	Жигд улаан ягаан өнгөтэй, өөхний өнгө цаганаас үл мэдэг цагаан шаргал түяатай, хуршиж шарласан шинж тэмдэггүй.	Сул давстай, үндсэн түүхий эдийн амт, давамгайлсан, туслах түүхий эдийн өөрийн өвөрмөц үнэртэй.
Бүтэн утлагат хиам	Бүрхүүл хальс нь гэмтээгүй, хуурай, цэвэрхэн, жигд үрчийсэн байна.	Зүсэхэд бутарч унахааргүй, таташ нь нягт хатуу, өөх нь жигд тархсан, хөндий зайд үүсээгүй	Тод улаан хүрэн өнгөтэй.	Бага зэрэг шорвогдуу, амт оруулагч бодис, болон утааны тод амт, үнэртэй.
Хагас утлагат хиам	Бүрхүүл хальс нь гэмтээгүй, хуурай, цэвэрхэн, гадаргуу нь бага зэрэг үрчгэр байна.	Таташ нь нягт, өөх мах нь жигд тархсан, зүсэлтэнд бутарч унахааргүй, хөндий зайд үүсээгүй байна	Улаавтар хүрнээс улаан хүрэн өнгөтэй.	Давсархаг, амт оруулагч бодис болон бага зэрэг утааны зөөлөн амт үнэртэй.
Зайдас	Бүрхүүл хальс нь гэмтээгүй, гадаргуу нь цэвэр, толбогүй байна.	Таташ нь жигд холилдсон, нягт савлагдсан, бутарч унахааргүй, мэдэгдэхүйцээр бүлх, шөрмөс гэх мэт холбогч эдгүй байна.	Улаавтар ягаан	Сул давстай, амт оруулагч бодис болон бүтээгдэхүүний өвөрмөц аятайхан, амт, үнэртэй, гадны ямар нэгэн амт, үнэргүй байна.
Цагаан зайдас	Бүрхүүл хальс нь гэмтээгүй, гадаргуу нь цэвэр, толбогүй байна.	Таташ нь жигд холилдсон, мэдэгдэхүйцээр бүлх, шөрмөс гэх мэт холбогч эдгүй байна.	Цагаан саарал	
Царцмаг	Бүрхүүл хальс нь гэмтээгүй, гадны бохирдолгүй байна.	Таташ нь жигд холилдсон, тосорхог зөөлөн бүтэцтэй.	Цайвардуу шаргал өнгөтэй байна.	Үнэр, амт оруулагч бодисуудын өвөрмөц аятайхан амт, үнэртэй, гадны ямар нэгэн амт үнэргүй байна.

Төрөл бүрийн хиамны физик, химиийн үзүүлэлт

Бүтээгдэхүүний төрөл	Үзүүлэлт					
	Чийг, % ихгүй	Тослог, % багагүй	Уураг, % багагүй	Цардуул, % ихгүй	Давс, %	Нитрит мг/1кг-д, ихгүй
Бүтэн утлагат хиам	40-45	15,0	30,0	-	2,8-3,5	5,0
Хагас утлагат хиам	45-50	25-30,0	20,0	-	2,5-3,0	5,0
Чанамал хиам	54-62	13,0	12,0	-	1,5-2,8	5,0
Зайдас	65,0	10,0	15,0	-	1,6-2,3	5,0
Царцмаг	55-60	20,0	16,0	-	1,8-2,5	5,0

Жич: Цагаан зайдсанд нитритийн хэмжээг тодорхойлохгүй.

Төрөл бүрийн хиам, гахай махны аюулгүй байдлын үзүүлэлт

Бүтээгдэхүүний нэр	Үзүүлэлтүүд	Зөвшөөрөгдөх хэмжээ, мг/кг, ихгүй
Хорт элементүүд		
Хар тугалга		0,5
Хүнцэл		0,1
Кадьми		0,05
Мөнгөн ус		0,03
Бенз/а/пирен		0,001
Нитрозамин /НДМА ба НДЭА-н нийлбэр/		0,002/0,004
Эм бэлдмэл /антибиотик/-ийн үлдэгдэл		
Левомицетин		Илрэх ёсгүй
Тетрациклиний бүлэг		Илрэх ёсгүй
Гризин		Илрэх ёсгүй
Бацитрацин		Илрэх ёсгүй
Пестицидийн үлдэгдэл		
Гексахлорциклогексан /α β γ изомер/		0,1
ДДТ ба түүний метаболитууд		0,1
Цацрагийн бохирдол		
Цезий-137		160
Стронций-90		50

Жич: Дээрх үзүүлэлтүүдийг МХЕГ-ын баталгаат лабораторид тодорхойлуулж баталгаажуулсан байна.

Төрөл бүрийн хиам, гахайн махны савласалт, хаяглалт

Нэр төрлөөс нь хамааруулан “MNS 5547:2005, Хүнсний бүтээгдэхүүний нийлэг сав баглаа боодол. Техникийн шаардлага” стандартын шаардлага хангасан зориулалтын хиймэл бүрхэвч болон бод, бог малын олгой, нарийн гэдэс, үхрийн хос, улаан хоолойн хальс, давсагт савласан байна. Савласан бүтээгдэхүүнийг нэр төрлөөр нь төрөлжүүлэн багцалж, хүнсний зориулалтын хуванцар тэвшинд савласан байна.

Савласан бүтээгдэхүүн нь “MNS SAC 1:2007, Савласан хүнсний бүтээгдэхүүний шошгололтод тавих ерөнхий шаардлага” стандартын шаардлага хангасан шошготой байна. Шошгон дээр түүний онцлог шинж чанар, хэрэглэх заавар, чанарын тэмдэг, үндэсний тохирлын тэмдэг зэргийг тусгасан байна.

Бүтээгдэхүүнийг ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан зориулалтын хөргүүртэй тээврийн хэрэгслээр бохирдлоос хамгаалж тээвэрлэнэ.

Дөрөв.Хиам нийлүүлэх үнийн саналын маягт

[огноо]

“ДЦС-4” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Ү.ТӨМӨРХУЯГ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [**санал болгож буй нэгж үнийг тоогоор болон үсгээр**] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу захиалгаар нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаarahгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших	1.1.	Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт	2.1.	Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх	3.1.	Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх	4.1.	Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа	5.1.	Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат хугацаа [нэг] жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах	6.1.	Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. Зах зээлийн үнэ огцом өөрчлөгдсөн тохиолдолд өрсөлдөгч компаниудын үнийн харьцуулалтыг үндэс болгоно
7. Төлбөр	7.1.	Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь	8.1.	Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах	9.1.	Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах	10.1.	Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх	11.1.	Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. Захиалагч чанарын баталгааны бичиг, худалдан борлуулах зөвшөөрлийг шалгана.
1.2. Нийлүүлэх барааны сав, баглаа боодол нь баталгаажсан эсэхийг шалгана |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх баримт бичгүүд:
1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь, зарлагын баримт;
2) барааны гарал үүслийн гэрчилгээ.
1 жилийн хугацаанд саадгүй нийлүүлнэ. |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | 5.1. Нийлүүлэгч нь тээвэрлэлтийн болон ашиглалтын явцад баглаа боодол гэмтсэн, чанар өнгө үзэмж алдагдсан тохиолдолд 100 хувь сольж нийлүүлэх ба үүнээс гарах зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна. |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | 7.1. Нийлүүлэгчид Урьдчилгаа төлбөр олгохгүй бөгөөд гэрээгээр нийлүүлсэн барааны төлбөрийн нэхэмжлэх зарлагын баримт, холбогдох баримтуудыг үндэслэн захиалагч бараа хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төлбөрийг хийнэ. |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ | <p>Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн барааны үнийн дүнд хэтэрсэн гүйцэтгээгүй үүргийн дүнгийн хоног дутамд 0,1%-ийн алданги ноогдуулна.</p> <p>Захиалагч нийлүүлэгчийн төлбөрийг хугацаа хоцроосон тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн дүнгийн хэтэрсэн хоног дутамд 0,1%-ийн алданги ноогдуулна.</p> <p>Алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн дүнгийн 30%-аас хэтрэхгүйбайна.</p> |

¹ Ихэнхтохиолдолд, нэгдолоохоногтооногдуулахалдангигэрээнийүнийн алдангийннийтдунгэрээнийүнийндүнгийн 10 хувиастустусхэтрэхгүй.

БАТЛАВ.

ДЦС-4 ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ

ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

ЗАХИРАЛ

ТӨРӨЛ БУРИЙН ХИАМ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар №

Улаанбаатар хот

Нэг талаас “**ДЦС-4” ТӨХК** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **ХХК** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2019 оны ____ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **Төрөл бүрийн хиам нийлүүлэх ХХА-2019/224-1-г** (цаашид “бараа” гэх) (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрч 1 жилийн хугацаатай гэрээг байгуулав.. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь барааг захиалагчийн захиалгын дагуу нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:“ДЦС-4” ТӨХК-ИЙН

“.....” ХХК-ИЙН

МЕНЕЖЕР

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“.....” ХХК-ИЙН

МЕНЕЖЕР